БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/120/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 16

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 19

**4.1 Ерөнхий зүйл** ........ 19

**4.2 Материаллаг байдал** ........ 19

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 19

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 19

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 19

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 20

**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 20

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 20

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 21

**5.1 Төлбөрийн акт** ........ 21

**5.2 Албан шаардлага** ........ 21

**5.3 Зөвлөмж** ........ 21

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Ч.БАХЫТЖАН ТАНАА

2023.02.24 № 258
танай___________-ны № ___________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй.

**Аудитын гол асуудал**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,861,500.00** | **16,262,177.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,800,000.00 | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 1,800,000.00 | - |
| **3121** | **Төгрөг** | 1,800,000.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,800,000.00 | - |
| **33** | **АВЛАГА** | 1,300,000.00 | 5,050,777.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,300,000.00 | 3,120,777.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 1,930,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 1,930,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,761,500.00 | 11,211,400.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,761,500.00 | 11,211,400.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 414,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,709,020.00 | 5,744,820.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,052,480.00 | 5,052,480.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,815,420,043.40** | **13,735,545,606.85** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 14,815,420,043.40 | 13,735,545,606.85 |
| **392** | **Биет хөрөнгө** | 14,798,031,043.40 | 13,712,156,606.85 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,199,859,764.00 | 1,224,359,764.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (121,601,763.59) | (179,820,394.21) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 130,409,999.00 | 130,409,999.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (67,234,166.74) | (73,969,166.74) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,332,659.00 | 111,012,659.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (46,705,156.42) | (58,973,296.08) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 97,374,635.00 | 97,374,635.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (53,281,164.18) | (63,201,361.05) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 13,365,425,036.00 | 13,365,425,036.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,028,109,618.12) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 298,151,833.00 | 315,151,833.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (90,700,631.67) | (127,503,482.95) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,389,000.00 | 23,389,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,389,000.00 | 23,389,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **14,829,281,543.40** | **13,751,807,783.85** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,606,745.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,606,745.00 | - |
| **413** | **Өглөг** | 5,606,745.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,606,745.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **14,823,674,798.40** | **13,751,807,783.85** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 14,823,674,798.40 | 13,751,807,783.85 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 137,765,376.00 | 143,765,376.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 137,765,376.00 | 143,765,376.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 14,488,422,947.64 | 13,410,555,933.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 14,488,422,947.64 | 14,488,422,947.64 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (1,077,867,014.55) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 197,486,474.76 | 197,486,474.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **14,829,281,543.40** | **13,751,807,783.85** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **14,663,155,521.00** | **1,005,352,250.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **14,663,155,521.00** | **1,005,352,250.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 13,742,692,485.00 | 61,500,000.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 13,742,692,485.00 | 61,500,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,309,072.00 | 12,926,350.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 4,210,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,309,072.00 | 4,200,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 4,516,350.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 868,980,500.00 | 930,925,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 868,980,500.00 | 923,403,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 7,522,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,173,464.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,173,464.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,000,423,522.21** | **2,083,219,264.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,000,423,522.21** | **2,083,219,264.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 945,399,840.21 | 2,012,217,259.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 566,821,844.00 | 586,406,578.00 |
| 210101 | Үндсэн цалин | 403,572,334.00 | 419,686,344.00 |
| 210102 | Нэмэгдэл | 151,169,510.00 | 112,471,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 12,080,000.00 | 54,248,334.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,611,800.00 | 73,534,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,713,800.00 | 48,125,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,724,500.00 | 12,673,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,779,600.00 | 3,396,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 944,900.00 | 849,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,449,000.00 | 8,490,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,030,500.00 | 41,852,698.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,772,000.00 | 4,453,854.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,805,300.00 | 35,339,797.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,453,200.00 | 2,059,047.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,336,199.00 | 46,071,431.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,338,150.00 | 5,821,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,615,849.00 | 34,502,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,278,200.00 | 5,577,431.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 104,000.00 | 170,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,282,900.00 | 1,191,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,282,900.00 | 1,191,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,635,100.00 | 4,850,910.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,218,600.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 1,332,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,416,500.00 | 3,518,710.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,239,600.00 | 4,198,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,239,600.00 | 4,198,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,085,500.00 | 2,400,220.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 854,700.00 | 880,290.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 619,000.00 | 462,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 50,000.00 | 90,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 104,200.00 | 183,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 141,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 198,200.00 | 559,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,800.00 | 74,430.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 182,600.00 | 8,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 244,356,397.21 | 1,251,710,722.55 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,347,496.00 | 99,318,686.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,056,060.00 | 337,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 97,952,841.21 | 1,152,054,436.55 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,023,682.00 | 71,002,005.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 7,522,100.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 7,522,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 55,023,682.00 | 52,761,500.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 2,173,464.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 23,746,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 44,850,218.00 | 29,014,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,000,000.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 10,718,405.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,718,405.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,662,731,998.79** | **(1,077,867,014.55)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **13,662,731,998.79** | **(1,077,867,014.55)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **920,463,036.00** | **943,852,250.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **920,463,036.00** | **943,852,250.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,309,072.00 | 12,926,350.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4,210,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,309,072.00 | 4,200,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 4,516,350.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 868,980,500.00 | 930,925,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 868,980,500.00 | 923,403,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | 7,522,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,173,464.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,173,464.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **905,873,036.00** | **940,972,250.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **905,873,036.00** | **940,972,250.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **851,557,172.00** | **869,970,245.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 533,388,300.00 | 593,834,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 367,319,400.00 | 420,153,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 147,948,900.00 | 112,471,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,120,000.00 | 61,208,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 81,075,300.00 | 73,534,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,459,800.00 | 48,125,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,153,900.00 | 12,673,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,123,100.00 | 3,396,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,030,700.00 | 849,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,307,800.00 | 8,490,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,856,900.00 | 41,949,996.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,598,400.00 | 3,551,152.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,805,300.00 | 35,787,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,453,200.00 | 2,611,744.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,033,680.00 | 43,316,533.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,830,900.00 | 5,830,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,924,580.00 | 31,866,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,278,200.00 | 5,530,133.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 88,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,282,900.00 | 1,194,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,282,900.00 | 1,194,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,284,700.00 | 4,879,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,479,200.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 1,479,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,805,500.00 | 3,400,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,495,300.00 | 4,198,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,495,300.00 | 4,198,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,626,000.00 | 2,346,730.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 854,700.00 | 826,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 619,000.00 | 462,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 50,000.00 | 90,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 104,200.00 | 183,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 141,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 738,700.00 | 559,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,800.00 | 74,430.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 182,600.00 | 8,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 153,514,092.00 | 104,716,686.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 152,421,992.00 | 104,379,086.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,092,100.00 | 337,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **54,315,864.00** | **71,002,005.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 7,522,100.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 7,522,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 54,315,864.00 | 52,761,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 2,173,464.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 23,746,700.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 44,142,400.00 | 29,014,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,000,000.00 | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 10,718,405.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,718,405.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **14,590,000.00** | **2,880,000.00** |
| 140007 | Хүлээн авсан хүүний орлого | | |
| 140008 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,790,000.00** | **4,680,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,790,000.00** | **4,680,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,790,000.00 | 4,680,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,790,000.00 | 4,680,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(12,790,000.00)** | **(4,680,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 1,800,000.00 | (1,800,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 1,800,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,800,000.00 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 120,376,376.00 | 125,123,361.00 | 804,949,063.08 | | 1,050,448,800.08 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **120,376,376.00** | **125,123,361.00** | **804,949,063.08** | **0.00** | 1,050,448,800.08 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -55,010,227.31 | | -55,010,227.31 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **137,765,376.00** | **197,486,474.76** | **14,488,422,947.64** | **0.00** | 14,823,674,798.40 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **137,765,376.00** | **197,486,474.76** | **14,488,422,947.64** | **0.00** | 14,823,674,798.40 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **137,765,376.00** | **197,486,474.76** | **14,488,422,947.64** | **0.00** | 14,823,674,798.40 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 6,000,000.00 | | | | 6,000,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -1,077,867,014.55 | | -1,077,867,014.55 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,765,376.00** | **197,486,474.76** | **13,410,555,933.09** | **0.00** | 13,751,807,783.85 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 1,800,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 931,925,900.00 | 923,564,645.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 931,925,900.00 | 923,564,645.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 871,642,300.00 | 863,281,045.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 593,834,100.00 | 593,834,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 420,153,600.00 | 420,153,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 112,471,900.00 | 112,471,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 61,208,600.00 | 61,208,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,534,800.00 | 73,534,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,125,300.00 | 48,125,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,673,300.00 | 12,673,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,396,300.00 | 3,396,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 849,100.00 | 849,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,490,800.00 | 8,490,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,787,100.00 | 41,949,996.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000.00 | 3,551,152.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,787,100.00 | 35,787,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 2,611,744.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,800,300.00 | 40,167,333.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,830,900.00 | 5,830,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,757,600.00 | 28,757,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,123,100.00 | 5,490,133.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,700.00 | 88,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,194,200.00 | 1,194,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,194,200.00 | 1,194,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,879,200.00 | 4,879,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,479,200.00 | 1,479,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,400,000.00 | 3,400,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,494,600.00 | 4,198,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,494,600.00 | 4,198,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,626,000.00 | 2,346,730.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 826,800.00 | 826,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 462,200.00 | 462,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,500.00 | 90,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,100.00 | 183,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 141,300.00 | 141,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 559,900.00 | 559,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 146,600.00 | 74,430.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 215,600.00 | 8,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 102,492,000.00 | 101,176,686.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,400,000.00 | 100,839,086.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,092,000.00 | 337,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 60,283,600.00 | 60,283,600.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 7,522,100.00 | 7,522,100.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 7,522,100.00 | 7,522,100.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,761,500.00 | 52,761,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,746,700.00 | 23,746,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,014,800.00 | 29,014,800.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 931,925,900.00 | 921,764,645.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 931,925,900.00 | 921,764,645.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 924,403,800.00 | 914,242,545.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 7,522,100.00 | 7,522,100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 62 | 62 |
| 620001 | Удирдах ажилтан | 19 | 19 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 25 | 25 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **62.0** | **62.0** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 26.00 | 26.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 14.00 | 14.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 18.00 | 18.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11,369,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,369,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,369,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,149,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,109,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,220,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,220,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 12,926,350.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,926,350.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,210,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,200,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,516,350.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын зорилго нь Засгийн газар болон аймгийн үндсэн чиглэл, бодлого үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутагтаа хэрэгжүүлэх, ард иргэдэд хүргэх, шуурхай үйлчлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Төр засгийн бодлогыг орон нутгийн онцлогт уялдуулан хэрэгжүүлэх,
- Аймгийн дэвшүүлсэн зорилго, зорилтыг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх,
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, явуулах ажлын чиглэл тодорхойлох,
- Сумын Засаг даргыг мэдээллээр хангах,
- Ард иргэдийн өргөдөл гомдол, санал санаачлалыг дэмжих шийдвэрлэх,
- Ард иргэдэд түргэн шуурхай үйлчлэх,
- Ард иргэдийн тав тухтай аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжоор хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2020 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,077.5 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,800.0 | | -1,800.0 |
| Авлага | 1,300.0 | 5,050.8 | 3,750.8 |
| Бараа материал | 10,761.5 | 11,211.4 | 449.9 |
| Үндсэн хөрөнгө | 14,815,420.0 | 13,735,545.6 | -1,079,874.4 |
| **Нийт хөрөнгө** | **14,829,281.5** | **13,751,807,8** | **-1,077,473.4** |
| Өр төлбөр | 5,606.7 | | -5,606.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 14,823,674.8 | 13,751,807.8 | -1,071,867.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **14,829,281.5** | **13,751,807,8** | **-1,077,473.4** |

Мөнгөн хөрөнгийн данс жилийн эцэст үлдэгдэлгүй ба авлагын данс 3.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын данс 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 1,079.8 сая төгрөгөөр буурсан нь ОНХС-аас нийлүүлсэн 61.5 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 4.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, тайланд онд орлого авсан 6.0 сая төгрөгийн газрын үнэлгээгээр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн 1152.0 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Жилийн эцэст өр төлбөргүй гарсан ба тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 1,071.8 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 876.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсвийг 35.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 924.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 7.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 923.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 7.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, батлагдсан төсвөөс 1.0 сая төгрөг дутуу олгосон ба жилийн эцэст 9.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 921.7 сая төгрөг буюу 98.4 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 582,789.3 | 573,628.0 | 9,161.3 | 98.4% |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 275,253.0 | 275,253.0 | 0 | 100% |
| 3 | Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж | 29,014.8 | 29,014.8 | 0 | 100% |
| 4 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,746.7 | 23,746.7 | 0 | 100% |
| 5 | Нөөц хөрөнгө | 12,600.0 | 12,164.9 | 0 | 100% |
| 6 | ОНХС - Итгэлцүүрээр олгох | 7,522.1 | 7,522.1 | 0 | 100% |
| | **Дүн** | **930,925.9** | **921,764.6** | **9,161.3** | 98.4% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болон нөөц хөрөнгөөс 12.9 сая төгрөгийн санхүүжилт авч, тээвэр шатахууны зардалд 3.1 сая төгрөг, хичээл үйлдвэрлэл, дадлага хийх зардалд 8.2 сая төгрөг зарцуулж, 1.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/57 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын сууриь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,000.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 10.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад төсвөөс хэмнэсэн 9.1 сая төгрөгийг жилийн эцэст төвлөрүүлэн ажилласан байна.Тайланд онд төрөл бүрийн спортын арга хэмжээ, шагналд зориулан 13.2 сая төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээнээс 1,037.2 сая төгрөгийн 22 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах мэдээллээс 4 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 923.4 сая төгрөгийн 12 мэдээллийг бүрэн оруулсан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 113.8 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаанд байршуулж, 21.3 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах мэдээллээс 2 мэдээллийг байршуулаагүй шилэн дансны хэрэгжилт 81.3 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төсвөөс зарцуулагдаагүй 1.8 сая төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлээгүй, 0.3 сая төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр харуулаагүй орхигдуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилт болон Шилэн дансанд мэдээлэл, жилийн эцсийн тооллого, шатахуун зарцуулалттай холбоотой 86.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнөөс биелэлт нь 75 %-тай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 2.1 | 2 | 2.1 | **100%** |
| Албан шаардлага | 2 | 86.8 | 1 | 33.1 | 50% |
| **Нийт дүн** | **4** | **88.9** | **3** | **35.2** | **75%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,034.1 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,034.1 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан дахь зам гүүрийн барилга байгууламж дансанд тусгасан 13,365,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд элэгдэл байгуулаагүй байсан алдаа зөрчилд тайлант оны 1,028.1 сая төгрөгийн элэгдлийг нөхөн байгуулж, тайланд залруулсан.

Шинээр бүртгэсэн 6.0 сая төгрөгийн газар эзэмших эрхийг санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлагнасныг Засгийн газрын капитал дансанд залруулав.

Аудитаар нийт 8.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8.3 сая төгрөгийн зөрчилд нэг албан шаардлага хүргүүлсэн болно.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага өгөв.Үүнд:

1.Тээвэр шатахууны зардалд зарцуулсан 12.3 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 16.4 сая төгрөгийн шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй, шатахуун зарцуулалтын тооцоог хийж баримтжуулаагүй, зөвхөн даргын цохолтоор шатахуун олгож ирсэн бөгөөд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй.

2.Төрөл бүрийн спортын арга хэмжээ, шагналд зориулан 13.2 сая төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан зөрчлүүдийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

**1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*2.1.Илрүүлэлт:*

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээнээс 1,037.2 сая төгрөгийн 22 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах мэдээллээс 4 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 923.4 сая төгрөгийн 12 мэдээллийг бүрэн оруулсан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 113.8 сая төгрөгийн 8

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэдээллийг хугацаанд байршуулж, 21.3 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах мэдээллээс 2 мэдээллийг байршуулаагүй шилэн дансны хэрэгжилт 81.3 хувьтай байна.

2.2. *Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг мөрдөж мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах, гарсан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зам, гүүр барилга байгууламжид элэгдэл байгуулаагүй | 1 | 1,028,109.6 | 1 | 1,028,109.6 | | | 1 | 1,028,109.6 | | | | |
| Газар эзэмших эрхийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн | 1 | 6,000.0 | | | 1 | 6,000.0 | 1 | 6,000.0 | | | | |
| **Дүн** | **2** | **1,034,109.6** | **1** | **1,028,109.6** | **1** | **1,034,109.6** | **1** | **1,034,109.6** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тээвэр шатахууны зардлыг шууд зардлаар бүртгэсэн, хяналтгүй зарцуулсан | 1 | 28,757.6 | | | 1 | 28,757.6 | | | | | | |
| **Дүн** | **1** | **28,757.6** | | | **1** | **28,757.6** | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 21.3 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, 2 мэдээллийг байршуулаагүй | 1 | 21,300.0 | | | | | 1 | 21,300.0 |
| **Дүн** | **1** | **21,300.0** | | | | | **1** | **21,300.0** |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсвийн хөрөнгөөр спортын арга хэмжээ зохион байгуулж, шагнал гардуулсан | 1 | 13,179.5 | | | 1 | 13,179.5 | | |
| **Дүн** | **1** | **13,179.5** | | | **1** | **13,179.5** | | |
| **Нийт дүн** | **2** | **34,479.5** | | | 1 | 13,179.5 | 1 | 21,300.0 |